БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ  ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган сумын ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код: БӨА-2023/48/НА-СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Өлгий хот<br>2023 он | Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: М.Хуанган<br>Утас: 70422954 Цахим хаяг: кhuanganm@audit.gov.mn<br>Аудитын менежер:  Х.Женисбек<br>Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn<br>“Анализ старт Аудит” ХХК-ны захирал: Н.Энхтуяа<br>Утас: 99075818 Цахим хаяг: asaudit.mn@gmail.com<br>Аудитор: А.Батжаргал<br>Утас: 99291595 Цахим хаяг:asaudit.zul@gmail.com |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу. .

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ ........ 3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ ........ 4
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА ........ 9
4. АУДИТЫН ТАЙЛАН ........ 13
4.1 Ерөнхий зүйл ........ 13
4.2 Материаллаг байдал ........ 13
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт ........ 14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ........ 14
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ........ 14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ........ 14
4.5.1 Завсрын аудитын талаар ........
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ........ 15
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ ........ 15
5.1 Төлбөрийн акт ........ 15
5.2 Албан шаардлага ........ 15
5.3 Зөвлөмж ........ 15
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.... **Error! Bookmark not defined.**

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын стандарт |

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgii@audit.gov.mn

БУЛГАН СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
3 ДУГААР СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
Д.АМГАЛАН ТАНАА

2023.02.17 № 95

танай ____________ -ны № ____________ -т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Булган сумын ерөнхий 3 дугаар сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Булган сумын ерөнхий 3 дугаар сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Сургуулийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлантай холбоотой онцлох асуудал гараагүй.

**Аудитын гол асуудал**

Хүнсний материалын бүртгэл, тооллого, хяналт тавих асуудлыг сайжруулах шаардлагатай байна.

**Бусад асуудлын хэсэг**

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшинийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР М.ХУАНГАН

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

**Төгрөгөөр**

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **34,215,977.00** | **56,835,436.25** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | - | 27,416,432.45 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | - | 27,416,432.45 |
| **3121** | **Төгрөг** | - | 27,416,432.45 |
| **31211** | Төрийн сангийн харилцах | - | 27,416,432.45 |
| **33** | **АВЛАГА** | 45,577.00 | 6,457,047.00 |
| **33402** | Татвар, НДШ – ийн авлага /ТӨҮГ/ | 45,577.00 | 6,457,047.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 34,170,400.00 | 22,961,956.80 |
| **354** | **Хангамжийн материал** | 34,170,400.00 | 22,961,956.80 |
| **35410** | Бичиг хэргийн материал | 298,000.00 | 197,300.00 |
| **35420** | Аж ахуйн материал | 14,349,600.00 | 10,250,950.00 |
| **35440** | Түлш, шатах тослох материал | 7,744,700.00 | 497,400.00 |
| **35460** | Хүнсний материал | 11,778,100.00 | 12,016,306.80 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **670,802,875.05** | **676,389,892.41** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 670,802,875.05 | 676,389,892.41 |
| **392** | **Биет хөрөнгө** | 659,842,875.05 | 665,429,892.41 |
| **39201** | Барилга, байгууламж, орон сууц | 684,673,172.16 | 692,673,172.16 |
| **39202** | Хуримтлагдсан элэгдэл | (39,151,352.16) | (52,201,802.88) |
| **39205** | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 10,439,976.00 | 19,534,976.00 |
| **39206** | Хуримтлагдсан элэгдэл | (5,015,984.01) | (6,082,368.17) |
| **39207** | Тавилга, аж ахуйн эд хогшил | 12,561,500.00 | 16,561,500.00 |
| **39208** | Хуримтлагдсан элэгдэл | (5,227,058.20) | (6,553,207.96) |
| **39214** | Бусад үндсэн хөрөнгө | 649,980.00 | 649,980.00 |
| **39215** | Хуримтлагдсан элэгдэл | (293,322.74) | (358,320.74) |
| **39217** | Ном | 1,205,964.00 | 1,205,964.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 10,960,000.00 | 10,960,000.00 |
| **39303** | Бусад биет бус хөрөнгө | 10,960,000.00 | 10,960,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **705,018,852.05** | **733,225,328.66** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **705,018,852.05** | **733,225,328.66** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 705,018,852.05 | 733,225,328.66 |
| **511** | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 95,629,950.00 | 95,629,950.00 |
| **51101** | Өмч:  - төрийн | 95,629,950.00 | 95,629,950.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 551,959,842.53 | 580,166,319.14 |
| **51210** | Өмнөх үеийн үр дүн | 551,959,842.53 | 551,959,842.53 |
| **51220** | Тайлант үеийн үр дүн | - | 28,206,476.61 |
| **51300** | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 57,429,059.52 | 57,429,059.52 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **705,018,852.05** | **733,225,328.66** |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

**Төгрөгөөр**

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **385,051,022.00** | **508,902,300.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **385,051,022.00** | **508,902,300.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 354,713,400.00 | 451,640,700.00 |
| **131001** | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | - | 439,640,700.00 |
| **131005** | Хөрөнгийн санхүүжилт | - | 12,000,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 26,008,000.00 | 57,261,600.00 |
| **132001** | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 26,008,000.00 | 57,261,600.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **401,249,272.48** | **480,695,823.39** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **401,249,272.48** | **480,695,823.39** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 394,612,300.48 | 469,479,710.88 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 292,858,800.00 | 340,281,557.06 |
| **210101** | Үндсэн цалин | 262,054,600.00 | 302,534,972.76 |
| **210102** | Нэмэгдэл | - | 25,076,945.37 |
| **210104** | Урамшуулал | 17,190,800.00 | 7,945,534.00 |
| **210105** | Гэрээт ажлын хөлс | 13,613,400.00 | 4,724,104.93 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 38,157,007.00 | 41,060,741.63 |
| **210201** | Тэтгэврийн даатгал | 22,894,207.00 | 28,100,619.52 |
| **210202** | Тэтгэмжийн даатгал | 3,815,700.00 | 3,279,706.86 |
| **210203** | ҮОМШӨ-ний даатгал | 3,052,560.00 | 2,566,325.36 |
| **210204** | Ажилгүйдлийн даатгал | 763,140.00 | 639,563.01 |
| **210205** | Эрүүл мэндийн даатгал | 7,631,400.00 | 6,474,526.88 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 29,253,190.00 | 34,473,750.00 |
| **210301** | Гэрэл, цахилгаан | 1,811,190.00 | 2,618,000.00 |
| **210302** | Түлш, халаалт | 27,442,000.00 | 31,855,750.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 5,183,060.00 | 3,370,500.00 |
| **210401** | Бичиг хэрэг | 305,900.00 | 2,120,300.00 |
| **210402** | Тээвэр, шатахуун | 3,717,260.00 | 1,250,200.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 9,750,400.00 | 19,805,993.20 |
| **210502** | Хоол, хүнс | 9,129,700.00 | 19,805,993.20 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 500,000.00 | 338,500.00 |
| **210604** | Урсгал засвар | 500,000.00 | 338,500.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 510,500.00 | 1,768,200.00 |
| **210801** | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 110,500.00 | 886,000.00 |
| **210806** | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | - | 882,200.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 18,399,343.48 | 28,380,468.99 |
| **210901** | Бараа үйлчилгээний бусад зардал | - | 10,670,736.35 |
| **210902** | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,064,000.00 | 2,201,750.00 |
| **210903** | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 16,335,343.48 | 15,507,982.64 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 6,636,972.00 | 11,216,112.51 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 5,914,500.00 | 10,672,300.00 |
| **213205** | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 5,914,500.00 | 10,672,300.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 722,472.00 | 543,812.51 |
| **213403** | Төвлөрүүлэх шилжүүлэг | 722,472.00 | 543,812.51 |

| | | | |
|---|---|---|---|
| 3 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **(16,198,250.48)** | **28,206,476.61** |
| 5 | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **(16,198,250.48)** | **28,206,476.61** |
| | | | |

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

**Төгрөгөөр**

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **385,051,022.00** | **496,902,300.00** |
| 13 | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **385,051,022.00** | **496,902,300.00** |
| 1310 | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 354,713,400.00 | 439,640,700.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | - | 439,640,700.00 |
| 1320 | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 26,008,000.00 | 57,261,600.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 26,008,000.00 | 57,261,600.00 |
| 2 | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **385,051,022.00** | **460,390,867.55** |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **381,701,022.00** | **460,390,867.55** |
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **375,064,050.00** | **449,149,255.04** |
| 2101 | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 290,634,700.00 | 342,341,255.04 |
| 210101 | Үндсэн цалин | 259,830,500.00 | 266,948,083.10 |
| 210102 | Нэмэгдэл | - | 62,984,505.89 |
| 210104 | Урамшуулал | 17,190,800.00 | 8,581,912.05 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 13,613,400.00 | 3,826,754.00 |
| 2102 | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 38,958,800.00 | 46,049,300.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 27,415,500.00 | 31,313,300.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,885,800.00 | 3,684,100.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,308,600.00 | 2,947,200.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 577,200.00 | 736,900.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,771,700.00 | 7,367,800.00 |
| 2103 | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 25,506,690.00 | 25,698,000.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,666,690.00 | 1,698,000.00 |
| 210302 | Түлш, халаалт | 23,840,000.00 | 24,000,000.00 |
| 2105 | **Нормативт зардал** | 11,762,200.00 | 20,425,200.00 |
| 210502 | Хоол, хүнс | 11,158,500.00 | 20,425,200.00 |
| 2106 | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 500,000.00 | 540,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 500,000.00 | 540,000.00 |
| 2108 | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 530,900.00 | 1,972,500.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | - | 1,972,500.00 |
| 2109 | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 1,916,000.00 | 12,123,000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | - | 9,728,300.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,916,000.00 | 2,394,700.00 |
| 213 | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **6,636,972.00** | **11,241,612.51** |
| 2132 | **Бусад урсгал шилжүүлэг** | 5,914,500.00 | 10,697,800.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 5,914,500.00 | 10,697,800.00 |
| 2134 | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн** | 722,472.00 | 543,812.51 |

| | | | |
|---|---|---|---|
| | **захирагчдад олгох татаас, санхүүжилт** | | |
| **213403** | Төвлөрүүлэх шилжүүлэг | 722,472.00 | 543,812.51 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | - | **36,511,432.45** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **3,350,000.00** | **9,095,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **3,350,000.00** | **9,095,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 3,350,000.00 | 9,095,000.00 |
| **225106** | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 3,350,000.00 | 9,095,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(3,350,000.00)** | **(9,095,000.00)** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | (3,350,000.00) | 27,416,432.45 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | 27,416,432.45 |

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

**Төгрөгөөр**

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| **C01** | **2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 95,629,950.00 | 57,429,059.52 | 568,158,093.01 | 721,217,102.53 |
| **C03** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | 95,629,950.00 | 57,429,059.52 | 568,158,093.01 | 721,217,102.53 |
| **C07** | Тайлант үеийн үр дүн | | | (16,198,250.48) | (16,198,250.48) |
| **C08** | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **95,629,950.00** | 57,429,059.52 | 551,959,842.53 | 705,018,852.05 |
| **D01** | **2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **95,629,950.00** | 57,429,059.52 | 551,959,842.53 | 705,018,852.05 |
| **D03** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **95,629,950.00** | **57,429,059.52** | **551,959,842.53** | 705,018,852.05 |
| **D08** | Тайлант үеийн үр дүн | | | 28,206,476.61 | 28,206,476.61 |
| **D09** | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **95,629,950.00** | **57,429,059.52** | **580,166,319.14** | **733,225,328.66** |

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

**Төгрөгөөр**

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | **Батлагдсан төлөвлөгөө** | **Гүйцэтгэл** |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **496,902,300.00** | **468,942,055.04** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 496,902,300.00 | 468,942,055.04 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 486,204,500.00 | 458,244,255.04 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 370,301,300.00 | 342,341,255.04 |
| **210101** | Үндсэн цалин | 282,805,300.00 | 266,948,083.10 |
| **210102** | Нэмэгдэл | 75,543,100.00 | 62,984,505.89 |
| **210104** | Урамшуулал | 11,952,900.00 | 8,581,912.05 |
| **210105** | Гэрээт ажлын хөлс | | 3,826,754.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 46,049,500.00 | 46,049,300.00 |
| **210201** | Тэтгэврийн даатгал | 31,313,500.00 | 31,313,300.00 |
| **210202** | Тэтгэмжийн даатгал | 3,684,100.00 | 3,684,100.00 |
| **210203** | ҮОМШӨ-ний даатгал | 2,947,200.00 | 2,947,200.00 |
| **210204** | Ажилгүйдлийн даатгал | 736,900.00 | 736,900.00 |
| **210205** | Эрүүл мэндийн даатгал | 7,367,800.00 | 7,367,800.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 26,618,000.00 | 26,618,000.00 |
| **210301** | Гэрэл, цахилгаан | 2,618,000.00 | 2,618,000.00 |
| **210302** | Түлш, халаалт | 24,000,000.00 | 24,000,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 20,425,200.00 | 20,425,200.00 |
| **210502** | Хоол, хүнс | 20,425,200.00 | 20,425,200.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 540,000.00 | 540,000.00 |
| **210604** | Урсгал засвар | 540,000.00 | 540,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 2,872,500.00 | 2,872,500.00 |
| **210806** | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 2,872,500.00 | 2,872,500.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 19,398,000.00 | 19,398,000.00 |
| **210901** | Бараа үйлчилгээний бусад зардал | 17,003,300.00 | 17,003,300.00 |
| **210902** | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,394,700.00 | 2,394,700.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 10,697,800.00 | 10,697,800.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 10,697,800.00 | 10,697,800.00 |
| **213205** | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 10,697,800.00 | 10,697,800.00 |
| **13** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **496,902,300.00** | **496,358,487.49** |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 439,640,700.00 | 439,640,700.00 |
| **131001** | Улсын төсвөөс санхүүжих | 439,640,700.00 | 439,640,700.00 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 57,261,600.00 | 56,717,787.49 |
| **132001** | Орон нутгийн төсвөөс | 57,261,600.00 | 56,717,787.49 |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | 27416432.45 |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 30.00 | 30.00 |
| **610001** | Төсвийн байгууллага | 30.00 | 30.00 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 30.00 | 30.00 |
| **620001** | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 |
| **620002** | Гүйцэтгэх ажилтан | 17.00 | 17.00 |
| **620003** | Үйлчлэх ажилтан | 12.00 | 12.00 |
| **650004** | СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД) | 30.00 | 30.00 |

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

**Нэмэлт төсөв аваагүй**

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

***Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар***

Булган сумын ерөнхий боловсролын 3 дугаар сургууль нь бага боловсрол олгох чиг үүрэгтэй байгууллага. Тус сургууль нь 2022 онд “Суралцагчийн сурлагын хоцрогдлыг нөхөж, бие даан сурах үйлийг дэмжихэд бүх талын оролцоог хангаан, сургалтын үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулах” зорилго дэвшүүлэн ажилласан байна.

Дээрх зорилгыг биелүүлэхээр дараах зорилтыг дэвшүүлэн ажилласан байна. Үүнд:

- Багш ээлжит хичээлийн бэлтгэлийг сургалтын хэлбэрээс үл хамааран чанартай бэлтгэж үр дүнтэй хэрэгжүүлэх
- Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтыг үр дүнтэй зохион байгуулж, элсэлтийн ерөнхий шалгалтын үр дүнг ахиулах
- Даалгаварт суурилсан арга зүйг боловсруулж,сургалтын чанарт ахиц гаргах.
- Багш,ажилчид,сурагчдыг стресээс сэргийлэх,айдас түгшүүр, сэтгэл зовнилгүй ажиллах,суралцахад сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх, ажлын байранд эерэг уур амьсгал бүхий байгууллагын соёлыг бүрдүүлэх
- Хүүхэд хамгааллын үйл ажиллагааны хэрэгжүүлэх, хүүхдийн бүх талын хөгжлийг дэмжин оролцоог хангаж, сургууль завсардахаас сэргийлэн, эцэг эх олон нийттэй хамтран ажиллах.
- Монгол хэл бичгийн чадварыг сайжруулах цогц үйл ажиллагааг хэрэгжүүлэх, түгээн дэлгэрүүлэх.
- "Монгол бичгийн үндэсний хөтөлбөр-3"-ын хүрээнд сургуулийн мэргэжлийн бүлгийг байгуулж, үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан хэрэгжүүлэх.
- Сурагчдыг тэгш хамааруулан сургах үйлийг дэмжих дэмжлэгийн багийн үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан хэрэгжүүлэх

## 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

***Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар***

Булган сумын ерөнхий боловсролын 3 дугаар сургууль нь Боловсролын тухай хууль, Бага, дунд боловсролын тухай хууль болон бусад боловсролын байгууллагуудад мөрдөж байгаа хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна.

Улсын Их Хурлаас Төсвийн тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар оруулсан өөрчлөлтөөр боловсролын салбарын байгууллагууд улсын төсвөөс санхүүжиж, БСШУС-ын харьяа Боловсролын ерөнхий газарт санхүүгийн тайлангаа нэгтгэлд тушаадаг болсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тухайлбал: Байгууллагаас гарч байгаа тушаал шийдвэр болон байгууллагын даргын тушаал шийдвэрийн хэрэгжилт, хуулийн үндэслэл бусад байгууллага, иргэдээс ирүүлсэн албан бичиг, өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн байдал, байгууллагын дотоод ажлын зохион байгуулалт хөдөлмөрийн сахилга, ажлын цаг ашиглалт, байгууллагын ажлын төлөвлөгөөний биелэлт, дээд байгууллагын тогтоол шийдвэрийн биелэлт, байгууллагын удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт зэрэг ажил хамрагдаж байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба нь тус аймгийн төсөвт байгууллагуудын санхүү, бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллага юм. Булган сумын ерөнхий боловсролын гуравдугаар сургууль 2022 онд шалгалтад хамрагдаагүй тул дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Булган сумын ерөнхий боловсролын гуравдугаар сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

***Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар***

Булган сумын ерөнхий боловсролын гуравдугаар сургуулийн захирлын 2022 оны 01 дугаар сарын 14-ны өдрийн А-03 тоот тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг ашигладаг байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Булган сумын ерөнхий боловсролын гуравдугаар сургуулийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 28.2 сая төгрөгөөр буюу 3.8 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| **Мөнгөн хөрөнгө** | - | 27416,4 | 27416,4 |
| **Авлага** | 45,5 | 6457,0 | -6411,4 |
| **Бараа материал** | 34170,4 | 22961,9 | 11208,5 |
| **Үндсэн хөрөнгө** | 670802,8 | 676389,8 | -5587,0 |
| Нийт хөрөнгө | **705018,8** | **733225,3** | **-28206,5** |
| **Өр төлбөр** | 0 | 0 | 0 |
| **Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/** | 95629,9 | 95629,9 | 0 |
| Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн | **705018,8** | **733225,3** | **-28206,5** |

Мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө дансанд өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна.

Мөнгөн хөрөнгийн данс оны эцэст 27.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан нь батлагдсан төсвөөс цалингийн зардал хэмнэснээс үүдэлтэй бөгөөд нийт цалингийн хэмнэлтээс 27.4 сая төгрөг буюу нийт хэмнэлтийн 94.4 хувийг эзэлж байна.

Оны эхэнд ХХОАТ-т 45.5 мянган төгрөгийн авлагатай байсныг барагдуулж, оны эцэст төсвөөс 6.4 сая төгрөгийг илүү шилжүүлж авлага үүсгэсэн байна.

Үндсэн хөрөнгийн данс 5.6 сая төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 9.1 сая, бусад эх үүсвэрээс 12.0 сая төгрөгийн хөрөнгө хүлээн авч үндсэн хөрөнгөнд тайлант онд 15.5 сая төгрөгийн элэгдэл байгуулсантай холбоотой байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй гэсний дагуу тус сургууль нь 2022-2023 оны төсвийн хүрээний мэдэгдлийг зохих журмын дагуу боловсруулан дээд шатны удирдлагад өгч батлуулсан байна.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 397.9 сая, орон нутгийн төсвөөс 57.0 сая, нийт зарлагыг 454.9 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсвийн захирагчаас төсвийг хянаж Төсвийн төслийн саналаас зардлыг 42.0 сая төгрөгөөр өсгөж 496.9 сая төгрөгөөр баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийн хуваарь өөрчлөлт орсон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр 439.6 сая төгрөгийг улсын төсвөөс, 57.2 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс бүрдүүлэхээр тусгасан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 439.6 сая төгрөгийн, орон нутгийн төсвөөс 56.7 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 468.9 сая төгрөг буюу 94.4 хувьтай байгаа нь үндсэн цалингийн зардлын төсвийг 15.8 сая төгрөгөөр, нэмэгдэл цалингийн төсвийг 12.5 сая төгрөгөөр, урамшуулалт цалингаас 3.3 сая төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/ төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний зардлын зориулалт | 416,350,800.00 | 388,390,555.04 | 27,960,244.96 | 93% |
| 2 | Бараа үйлчилгээний бусад нийтлэг зардлын зориулалт | 19,398,000.00 | 19,398,000.00 | 0.00 | 100% |
| 3 | Эрүүл мэндийн арга хэмжээ | | | 0.00 | |
| 4 | Боловсролын арга хэмжээ | 2,872,500.00 | 2,872,500.00 | 0.00 | 100% |
| 5 | Үдийн цай хөтөлбөр | 10,697,800.00 | 10,697,800.00 | 0.00 | 100% |
| 6 | Хүүхдэд ээлтэй сургалтын орчин | 26,618,000.00 | 26,618,000.00 | 0.00 | 100% |
| 7 | Боловсролын байгууллагын багш ажилчдын мэргэжил дээшлүүлэх | 540,000.00 | 540,000.00 | 0.00 | 100% |
| 8 | Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах | 20,425,200.00 | 20,425,200.00 | 0.00 | 100% |
| | Дүн | **496,902,300.00** | **468,942,055.04** | **27,960,244.96** | |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Булган сумын ерөнхий боловсролын гуравдугаар сургууль 2022 онд нэмэлт төсөв аваагүй байна.

### *3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн*

Булган сумын ерөнхий боловсролын гуравдугаар сургууль 2022 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Булган сумын ерөнхий боловсролын гуравдугаар сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах хууль тогтоомжийн хэрэгжилт, бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Улаанбаатар хотын “Анализ старт аудит” ХХК-ны аудитор А.Батжаргал гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Булган сумын ерөнхий боловсролын гуравдугаар сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн …… дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Булган сумын ерөнхий боловсролын гуравдугаар сургуулийн 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 401.2 сая төгрөгөөс

1.5 хувиар буюу 6.0 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад алдаа, зөрчил илрээгүй.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд Шилэн дансны мэдээллээс шалгах программд орсон мэдээллүүдийн хэрэгжилтийг шалгав. Шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 100 % байна.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд алдаа, зөрчилтэй асуудал гараагүй болно.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудитаар нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Булган сумын ерөнхий боловсролын гуравдугаар сургуульд завсрын аудит хийгдээгүй байна. Өмнөх оны аудитаар 8.0 сая төгрөгийн 2 албан шаардлага өгснийг хэрэгжүүлж ажилласан байна.

*Хүснэгт 4 Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | | | | | |
| Албан шаардлага | 2 | 8045.9 | 2 | 8045.9 | 100% |
| Зөвлөмж | | | | | |
| **Нийт дүн** | **2** | **8045.9** | **2** | **8045.9** | **100%** |

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгээ шинэчлэх,

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар санхүүгийн тайланд 4.8 сая төгрөгийн залруулга хийгдсэн.

Төсвийн гүйцэтгэлийн тайланд Орон нутгийн төсвийн санхүүжилтээс 0.5 сая төгрөгийн төвлөрүүлэг шилжүүлгийг цэвэрлээгүй, 4.3 сая төгрөгөөр орлогыг илүү тайлагнасан нийт 4.8 сая төгрөгийг буруу тайлагнасныг эх үүсвэрээс хасаж цэвэрлэж залруулав.

Аудитаар нийтдээ 20.3 сая төгрөгийн зөрчил илэрснээс 2.0 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 18.2 сая төгрөгийн 2 зөвлөмж өгөгдлөө.

### 5.1 Төлбөрийн акт

Аудитаар нийт 1.7 сая төгрөгийн зөрчил илэрч төлбөрийн акт тогтоосон. Үүнд:

1.Булган сумын зургаадугаар сургуулийн захирал нь Боловсрол, шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын хамтарсан 2021 оны А/35, А/10/9 тоот хамтарсан тушаалаар шинэчлэн баталсан “Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, зарим албан тушаалтанд ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлтийн дагуу захирлын ур чадварыг үнэлж дүгнээгүй байхад Булган сумын Засаг даргын 2022 оны 3 сарын 24 ны өдрийн А/21 дугаар захирамжийг үндэслэн нийт 2,081.6 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдэл авсныг нөхөн төлүүлэхээр төлбөрийн акт тогтоосон.

### 5.2 Албан шаардлага

Албан шаардлага өгөгдөөгүй.

### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

***1. Бараа материалын тооллоготой холбоотой асуудал***

*1.1.Илрүүлэлт:*

Хүнсний материалын оны эхний үлдэгдэлд байгаа 11.7 сая төгрөгийн материалд зарлагын гүйлгээ гараагүй байгаа нь хүнсний материалын үлдэгдлийн тооллогыг зохих журмаар хийж баталгаажуулаагүй, үлдэгдэл нь бодитой байгаа эсэх тодорхой бус байна.

*1.2. Өгсөн зөвлөмж*:

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заалтыг баримталж хүнсний материалыг хэрэгцээнд тулгуурлан худалдан авалт хийх, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-т заасныг дагуу хүнсний бараа материалын үлдэгдлийн тооллогыг бодитой хийж үлдэгдлийг баталгаажуулах, нярвын тооцоонд тавих хяналтыг сайжруулах.

***2. Авлагатай холбоотой асуудал***

*2.1.Илрүүлэлт:*

Сургууль нь цалингаас 23.1 сая төгрөгийн татвар суутгасан боловч оны эцэст төсвөөс татварт 6.4 сая төгрөгийг илүү шилжүүлж авлага үүсгэсэн байна.

*2.2. Өгсөн зөвлөмж*:

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалтыг баримталж тооцооноос илүү мөнгө шилжүүлж авлага үүсгэсэн зөрчлийг арилгах, авлага нэмж үүсгэхгүй байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын газарт 2023 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Санхүүгийн тайланг зөрүүтэй илэрхийлсэн байх. | 1 | 4329.6 | | | 1 | 4329.6 | 1 | 4329.6 | | | | |
| Санхүүгийн тайланг зөрүүтэй илэрхийлсэн байх. | 1 | 543.8 | | | 1 | 543.8 | 1 | 543.8 | | | | |
| Дүн | **2** | **4873.4** | | | **2** | **4873.4** | **2** | **4873.4** | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Бараа материалын тооллого хийгээгүй, үлдэгдлийг баталгаажуулаагүй байх | 1 | 11.778.1 | | | | | 1 | 11.778.1 | | | | |
| Оны эцэст авлага үүсгэсэн | 1 | 6.457.0 | | | | | 1 | 6.457.0 | | | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| байх | | | | | | | | | | | | |
| Шалгуур үзүүлэлт хангаагүй ур чадварын нэмэгдэл авсан | 1 | 981.6 | 1 | 981.6 | | | | | | | | |
| **Дүн** | **3** | **19.216.7** | **1** | **981.6** | | | **2** | **18.235.1** | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |
| Нийт дүн | | | | | | | | |